



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
РАШААНТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 7/66

Рашаант сум

Г Ажлын хэсэг томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.2, 47.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих Баяр наадам, Сургалт сурталчилгааны материал худалдан авах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Баянбаатар (Цэнгэл багийн засаг дарга)

Нарийн бичиг: Ц.Болормаа (Төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүн: Д.Нарантуяа (Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Дээрх ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  Б.АЛТАНГЭРЭЛ